



**БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЖИНСТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2022 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/60

Бодь


Бүх нийтээр их цэвэрлэгээ зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх нийтээр их цэвэрлэгээ хийх өдрийг сар бүрийн 15-нд зарлаж хэвшүүлж ажиллахыг Бодь 5 дугаар багийн Засаг дарга (Б.Ганцэцэг), Байгаль хамгаалагч (П.Батбаатар) нарт даалгасугай.
2. Бодь 5 дугаар багийн хоринуудын нийтийн эдэлбэр газарт, их цэвэрлэгээ хийх газрын хэмжээг хавсралтаар баталсугай.
3. Олон нийтийг хамарсан гудамж талбай, ажиллаж амьдардаг орчныхоо 50 метрээс доошгүй газрын хог хаягдлыг цэвэрлэж байгаль орчноо цэвэр ариун байлгахад идэвх санаачилгатай оролцохыг айл өрх болон нийт ард иргэдэд уриалсугай.
4. “Их цэвэрлэгээний өдөр”-ийг зохион байгуулахад удирдлага арга зүйгээр хангаж хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Цэрэнхүү), Байгаль орчны хяналтын улсын байцаагч (С.Ганцэцэг), унаа шатахууны зардлыг хангаж ажиллахыг Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Эрдэнэцэцэг), 5 дугаар багийн Засаг дарга (Б.Ганцэцэг) нарт үүрэг болгосугай.

642201111

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Сумъяа)-д даалгасугай.

ДАРГА  Р.БАТЖАРГАЛ

Сумын Засаг даргын 2022 оны 05 дугаар  
сарын 16. –ны өдрийн 1/16 дугаар  
захирамжийн 1. дүгээр хавсралт

Сумын нийтийн эдэлбэр газарт албан байгууллагууд  
их цэвэрлэгээ хийх газрын хуваарь

| № | Албан байгууллагын нэр | Цэвэрлэх газар, талбайн нэр хэмжээ   |
|---|------------------------|--|
| 1 | 2                      | 3  |
| 1 | 1 дүгээр хорин         | “Их хайрхан” дэлгүүрийн дээд өнцөгөөс баруун тийш Н.Мөнхжаргалын хашаа хүртэлх газар, урагшаа Түйн гол хүртэлх газар |
| 2 | 2 дугаар хорин         | Бодь овооноос Т.Наранбаатарын өвөлжөө хүртэлх газар, урагшаа Түйн гол хүртэлх газар                                  |
| 3 | 3 дугаар хорин         | Т.Наранбаатарын өвөлжөөнөөс Ц.Жаргалбаярын ногооны талбай хүртэл урагшаа Түйн гол хүртэлх газар                      |
| 4 | 4 дүгээр хорин         | Ц.Жаргалбаярын ногооны талбайгаас Ц.Батбаярын өвөлжөө хүртэлх газар урагшаа Түйн гол                                 |
| 5 | 5 дугаар хорин         | Ц.Батбаярын өвөлжөөнөөс Н. Мөнхжаргалын хашаа хүртэлх газар  |

оОо